



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын
бэлтгэл ажлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Статистикийн тухай хуулийн 17 дугаар зүйл, 18 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамж, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 76 дугаар тогтоол, Хүн ам, орон сууцны улсын тооллогын улсын комиссын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул дүүрэгт 2019 оны 01 дүгээр сарын 10-16-ны өдрийн хооронд явагдаж байгаа Хүн ам, орон сууцны туршилтын тооллогын тоологч, хянагч нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, аюулгүй байдлыг хангаж, хамтарч ажиллахыг дээрх дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/477 дугаар захирамжаар байгуулагдсан дүүргийн Тооллогын комиссын дарга нар Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэлийг хангах зорилгоор хорооны Засаг дарга нарт "Хүн ам, өрхийн мэдээллийн сан"-гийн алдааг засаж, баяжилт хийх чиглэлээр үүрэг өгч, гүйцэтгэлийг 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Статистикийн газарт ирүүлэхийг үүрэг болгосугай.

3. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд нийслэлд явагдаж байгаа туршилтын тооллогын явц, Хүн ам, өрхийн мэдээллийн санг сайжруулах талаар хороо, дүүргээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Д.Энхтөрд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН
БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ

Ж.БАТБАЯСГАЛАН